

**ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН Б ХЭСЭГТ ТАХЬ БОЛОН ТҮҮНИЙ  
АМЬДРАХ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,  
ОЛОН УЛСЫН ТАХЬ ГРУПП  
ХООРОНДЫН  
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Олон улсын тахь групп (цаашид “Талууд” гэх),

Энэхүү санамж бичгийг байгуулагч талууд болох Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Олон улсын тахь группын хамтын ажиллагааны хичээл зүтгэл болон бусад байгууллагуудын тусламж, дэмжлэгээр Говийн Их Дархан Цаазат Газар (ГИДЦГ)-ын “Б” хэсэгт тахийг уугуул нутагт нь сэргээн нутагшуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж ирсэн юм.

Тахийг эх нутагт нь сэргээн нутагшуулахаар 1990 оноос эхэлсэн хамтын ажиллагааны төслийн үр дүнд байгальдаа устаад байсан зэрлэг тахь ГИДЦГ-ын “Б” хэсгийн уудам говьд амжилттай дасан нутагшиж байна.

Тахь нутагшуулах уг төсөл болон бусад төслүүдийн ажлын үр дүнд тахь Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны ховордсон зэрэглэлийн “байгальдаа устсан” гэсэн ангиллаас гарч “устаж болзошгүй” ангилалд шилжсэн байна. Гэсэн ч ГИДЦГ-ын “Б” хэсэгт нутагшуулж байгаа тахийн популяци хязгаарлагдмал цөөн тоотой байгаа нь байгаль цаг уурын бэрхшээлд хэт эмзэг зүйл хэвээр байгааг харуулсаар байна.

Иймээс цаашид говийн байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицсон бие даан амьдрах чадвартай зэрлэг тахийн популяцийг ГИДЦГ-ын “Б” хэсэгт бий болгох зорилгоор хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай гэж талууд санал нэгтэй зөвшөөрөв.

Дор дурдсан зөвшилцөлд хүрэв:

### **1 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

Талууд энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд говийн байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицсон бие даан амьдрах чадвартай зэрлэг тахийн популяцийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

### **2 ДУГААР ЗҮЙЛ**

Талууд дараахь үүрэг хариуцлагыг хүлээнэ:

2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам дараах үүргийг хүлээнэ:

1. ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны зардлыг хариуцна. Үүнд: ажилчдын цалин, нийгмийн даатгал, ажлын байр, засвар үйлчилгээ, шатахуун, түлш болон бусад материалын зардал орно.
2. ГИДЦГ-ын “Б” хэсгийн өнөөгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
3. ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгааллын менежментийг сайжруулахад дэмжин ажиллах
4. Тахь үндэсний дэд хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлж ажиллах, сүргийг Монгол Улсад нутагшуулах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах
5. ГИДЦГ-ын “Б” хэсэгт байгалийн бэрхшээл ган, зуд тохиолдсон үед шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах, унаа тэрэг техник хэрэгсэлээр хангах,
6. Олон улсын болон Монголын судлаачдад говийн экосистемийн болон дараах чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэхэд холбогдох хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлэх. Үүнд: тахь, хулан, хар сүүлт, зээр болон биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт.
7. Санамж бичгийн хугацаанд Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төслийн үйл ажиллагаанд шаардлагатай багаж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, судалгааны материал, эм урвалжийг хил, гаалийн татвараас чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэхэд анхааран ажиллах,

## 2.2. Олон улсын Тахь группын хүлээх үүрэг:

1. ГИДЦГ-ын “Б” хэсэгт тахийг сэргээн нутагшуулах урт хугацааны төслийг дэмжин хэрэгжүүлэх
2. Тахийг сэргээн нутагшуулах болон түүнтэй уялдаатай бусад төслүүдийг дэмжих, шаардлагатай санхүүжилт бий болгоход дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах,
3. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн дэвшилтэт арга зүй, технологийг ашигласан судалгааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,
4. ОУТГ-ээс хийгдсэн бүх судалгааны материал, ажлын үр дүн нь Монголын талд нээлттэй байна.
5. ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны албан хаагчид, Монголын залуу судлаачдыг сургалтанд хамруулах, тэднийг сурч боловсрох хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
6. Монгол Улсын байгаль хамгаалах чиглэлийн хууль тогтоомж, ГИДЦГ-ын “Б” хэсгийн менежментийн төлөвлөгөөг мөрдлөг болгож, түүнийг хэрэгжүүлэхэд тусалж ажиллана.
7. ОУТГ өдөр тутмын үйл ажиллагаагаа тогтмол явуулж байх зорилгоор Улаанбаатар хотод ОУТГ-ийн Товчоо ажиллуулна. Энэ товчоо нь Монгол Улсын төрийн бус байгууллагын эрх, үүргийн хүрээнд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж албан ёсоор бүртгэгдсэн байна.

## 2.3. Хоёр талын харилцан хүлээх үүрэг:

1. ГИДЦГ-ын “Б” хэсгийн менежментийн төлөвлөгөөг хамтран боловсруулах, ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаатай холбоотой аливаа шийдвэр, төлөвлөгөө, мэдээллийг цаг тухай бүр харилцан мэдээлж байх;

2. Монгол болон олон улсын эрдэм шинжилгээний хамтын ажлыг дэмжих;
3. ГИДЦГ-ын “Б” хамгаалалтын захиргааны ажилтан, албан хаагчид, судлаачид, олон улсын мэргэжилтэнүүдийн туршлага солилцоог дэмжих;
4. Монгол Улсад байгаль хамгаалах чиглэлийн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлж ба/эсхүл хэрэгжүүлж буй байгууллагууд (GEF, WWF, GTZ, IUCN)-тай хамтран ажиллахыг эрмэлзэнэ.
5. Тахийг сэргээн нутагшуулах бусад төслүүдтэй (Хустай БЦГ, Хомын тал) хамтран ажиллах;
6. ГИДЦГ-ын “Б” хэсгийн менежменттэй холбоотой орон нутгийн иргэд, нөхөрлөлүүдийг чадавхижуулахад анхаарч ажиллах;
7. ГИДЦГ-ын “Б” хэсгийн говийн бүсэд нутгийн иргэд, малчдын нийгэм эдийн засгийг сайжруулах, орлогыг төрөлжүүлэх зорилгын үүднээс төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэрийг (эко аялал жуулчлал, бусад орлогын эх үүсвэр) бий болгох;
8. Санамж бичиг байгуулагч талууд хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлж, олон улсын зэрлэг амьтан хамгаалах ажил үйлсэлд ач холбогдол бүхий энэхүү төслийг хэрэгжүүлнэ.

### 3 ДУГААР ЗҮЙЛ

3.1. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийн үр дүнг талууд хамтран үнэлнэ. Энэхүү хамтын ажиллагаа, хамтын ажиллагааны үр дүнд бий болсон аливаа туршлага, мэдээллийг байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг бусад байгууллагуудтай хуваалцах боломжтой; оюуны өмчийн эрхийг хүндэтгэх.

3.2. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн аль нэг заалтыг хэрэгжүүлэх болон тайлбарлахтай холбоотой аливаа маргааныг талууд хоорондоо зөвлөлдөх болон/эсхүл хэлэлцээ хийх замаар найрсгаар шийдвэрлэнэ.

### 4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

4.4. Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх, хамтран ажиллахаар томилогдсон албан байгууллага, холбогдох албан тушаалтны хаяг:

<p>Монголын талыг төлөөлж:          Албан тушаал: Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны дарга          Хаяг: Говь-Алтай аймаг, Бугат сум, 1 дүгээр баг.          Имэйл: ggbspa@mpa.gov.mn          Утас: +976- 92177740</p>	<p>Олон улсын тахь группыг төлөөлж:          Албан тушаал: Олон улсын тахь группын ерөнхийлөгч          Хаяг: c/o Stiftung Wildnispark Zürich          CH-8135 Sihlwald, Switzerland          Имэйл: info@savethewildhorse.org          Утас: +41 44 722 55 22</p>
--	--

### 5 ДУГААР ЗҮЙЛ

5.1. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг нь талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын журмаа гүйцэлдүүлсэн тухайгаа бие биедээ мэдэгдсэн сүүлийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.2. Энэхүү санамж бичиг нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2031 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл буюу арван (10) жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Түүнээс хойш түүний хүчин төгөлдөр байх анхны буюу дараагийн аливаа хугацаа дуусахаас наад зах нь зургаан (6) сарын өмнө аль нэг тал нөгөө талдаа цуцлах тухайгаа албан бичгээр мэдэгдээгүй бол түүний хүчинтэй байх хугацаа дараагийн таван (5) жилээр аяндаа сунгагдана.

5.3. Талууд өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд энэхүү харилцан ойлголцлын санамж бичиг дуусгавар болсноор санамж бичгийн хүрээнд эхлүүлсэн төсөл, хөтөлбөр, аливаа санаачилгын хэрэгжилтэд болон дуусгавар болох үед хэрэгжиж эхлээгүй байгаа арга хэмжээнд нөлөөлөхгүй болно.

Үүнийг нотолж, дор дурдсан эрх бүхий этгээд энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийг ... оны ... дугаар сарын ... өдөр Улаанбаатар хотноо монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

БАТ-ӨЛЗИЙН БАТ-ЭРДЭНЭ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТУСГАЙ  
ХАМГААЛАЛТТАЙ БҮС НУТГИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

ДАШДЭМБЭРЭЛИЙН БАТМӨНХ

2022.05.10

ОЛОН УЛСЫН ТАХЬ ГРУППЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

РАЙНХАРД ШНИДРИГ

ОЛОН УЛСЫН ТАХЬ ГРУППЫН  
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

КРИСТИАН ШТАУФФЕР

**MEMORANDUM OF UNDERSTANDING  
BETWEEN  
THE MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM OF MONGOLIA  
AND  
THE INTERNATIONAL TAKHI GROUP  
ON COOPERATION IN THE FIELD OF CONSERVATION  
OF THE PRZEWALSKI'S HORSE AND ITS  
HABITAT IN THE GREAT GOBI "B" STRICTLY PROTECTED AREA**

The Ministry of Environment and Tourism of Mongolia and the International Takhi Group referred to as "Parties",

The two agreement parties, the Ministry of Environment and Tourism (MET) of Mongolia and the International Takhi Group (ITG) have through joint efforts and with the help of numerous partners and financial supporters, successfully reintroduced the Przewalski's horse (takhi) to the Great Gobi "B" Strictly Protected Area of Mongolia. While the takhi was extinct in the wild at the onset of the collaborative project in 1990, it now roams freely in the wide gobi of Great Gobi "B" Strictly Protected Area (GGBSPA).

The IUCN down listed the species to the "critically endangered" category - a spectacular success for Mongolia and its partners. However, there-introduced takhi population in the GGB SPA is still small and restricted in range making it vulnerable to catastrophic events and stochastic effects.

The partners agree that cooperation is essential in order to achieve a self-sustaining, free ranging takhi population in the GGB SPA. To safeguard the takhi population, a national and globally important species, reintroduced in the Dzungarian Gobi, surviving independently from human interventions in the future, through cooperation in the field of conservation.

Have reached the following understanding:

**ARTICLE 1**

Within the framework of this Memorandum of Understanding, the Parties will work together to increase the population of wild Przewalski's horses that are adapted to the natural and climatic conditions of the Gobi.

**ARTICLE 2**

The Parties have agreed to following responsibilities:

2.1. The Ministry of Environment and Tourism agrees to:

1. be responsible for the operation expenses of the GGB SPA's administration. The expenses include amongst others: Wages, social insurances, accommodations, infrastructure including its maintenance, supply of fuel and other material expenses;
2. implement the current management plan for the Great Gobi "B" Strictly Protected area;

3. maintain and improve the protection management of Great Gobi "B" Strictly Protected Area;
4. adopt and implement the national sub-program on takhi conservation and work towards implementation of the management plan for the reintroduction of takhi populations in Mongolia;
5. provide technical, logistical and other necessary assistance during natural disasters in the Great Gobi "B" Strictly Protected Area;
6. support international and Mongolian transdisciplinary research activities related to the Gobi ecosystem and various related fields such as takhi, goitered gazelle, asiatic wild ass, biodiversity, and climate change within the relevant legal framework;
7. support the facilitation of exemption of necessary project equipment, tools, research materials, medical supplies and services which are accepted internationally and within Mongolian laws and regulations, from national tax and customs for the duration of this MoU.

#### 2.2. The International Takhi Group agrees to:

1. support in the long-term restoration and conservation of Przewalski's horse in the Great Gobi "B" Strictly Protected Area;
2. use best efforts to support and collaborate in raising funds to finance mutually agreed projects relating to takhi conservation;
3. develop and implement state of the art research programs, which are accepted internationally as well as within the Mongolian laws and regulations;
4. guarantee that all research results are available in Mongolia;
5. provide training opportunities for GGB SPA's administration employees, Mongolian young researchers and support capacity building;
6. assist the implementation of the GGB SPA management plan and environmental laws and regulations of Mongolia;
7. maintain a permanent office in Ulaanbaatar city for daily operations, which is officially registered as a non-government organization of Mongolia and will adhere to the national laws and regulations.

#### 2.3. Both parties mutually agree to:

1. develop jointly the management plan of the GGB SPA and keep each other informed of strategic decisions related to the GGB SPA's administration in a timely manner;
2. facilitate Mongolian-international research cooperation;
3. facilitate exchange of knowledge between GGB SPA's administration employees, officers, scientists and international specialists;
4. cooperate with other organizations (GEF, WWF, GIZ, IUCN) that fund or/and implement projects and programs related to environmental protection in Mongolia;
5. cooperate with the Przewalski's horse re-introduction projects (Hustai National Park and Khomyn tal National park);

6. Facilitate local stakeholder empowerment and involvement in the management of the GGB SPA;
7. implement projects and programs and create sources of funding for the purpose of improving the socio-economic situation of local people and herders and diversifying their income in the GGB SPA region (e.g. Eco-tourism, alternative income schemes)
8. The parties should honorably fulfill their duties under the agreement to implement the project, which is significant to global conservation efforts.

### ARTICLE 3

3.1. Parties shall jointly evaluate the implementation results of this Memorandum of Understanding. Any experience and technical data deriving from this collaboration and cooperation can be shared with other entities working in the field of nature conservation, respecting intellectual property rights.

3.2. Any differences associated with the interpretation and implementation of this MoU shall be resolved amicably by means of consultations and/or negotiations between Parties.

### ARTICLE 4

4.1. The offices designated to coordinate and implement this MoU, and points of contact are:

<p>From Mongolian Side:  Title: Director of Great Gobi "B" Strictly Protected Area Administration  Address: Gobi-Altai Province, Bugat Soum, 1<sup>st</sup> Bag.  Email: ggbspa@mpa.gov.mn  Phone: +976-92177740,</p>	<p>From Switzerland side:  Title: President of ITG - International Takhi Group  Address: c/o Stiftung Wildnispark Zürich  CH-8135 Sihlwald, Switzerland  e-mail: info@savethewildhorse.org  Tlf: +41 44 722 55 22</p>
---	---

### ARTICLE 5

5.1. This MoU shall enter into force on the date of receipt of the last notification by which the Parties inform each other in writing about the completion of their internal procedures necessary for the entry into force of this MoU.

5.2. The MoU will be valid for 10 years from January 1st, 2021 until December 31st, 2031. Thereafter, the validity period shall be automatically extended for the next five (5) years unless either party notifies the other party in writing of the termination at least six (6) months before the expiration of any of its first or subsequent validity periods.

5.3. The termination of this MoU shall not, however, affect the completion of projects, programs and any other initiatives undertaken under this MoU and not fully implemented at the time of its termination, unless otherwise decided by the Parties.

In witness whereof, the undersigned, being duly authorized thereto, have signed this Memorandum of Understanding.

Done in Ulaanbaatar, on ..... 2022, in two originals, each in the Mongolian and English languages, all texts being equally authentic. In case of divergence in the interpretation of this MoU, the English text shall prevail.

MINISTER OF ENVIRONMENT AND  
TOURISM OF MONGOLIA  
BAT-ULZII BAT-ERDENE

Signature 

Date 2022.06.08,

PRESIDENT OF INTERNATIONAL  
TAKHI GROUP  
REINHARD SCHNIDRIG

Signature 

Date 6.4.2022

DEPARTMENT OF PROTECTED  
AREAS MANAGEMENT  
DASHDEMBEREL BATMUNKH

Signature 

Date 2022.05.10

INTERNATIONAL TAKHI GROUP  
VICE PRESIDENT  
CHRISTIAN STAUFFER

Signature 

Date 6.4.2022